

# **БДБ-4 Нэгдүгээр ангид шинээр элсэгч**

## **Албан ёсны мэдээлэл, Маягт БДБ-4**

Төрийн бус өмчийн сургууль, холимог өмчийн хөрөнгө оруулалттай сургуульд тухайн хичээлийн жилд нэгдүгээр ангид шинээр элсэгчдийн мэдээллийг нас, хүйс болон сургуульд орохын өмнө сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан эсэх мэдээллийг харуулна.

**Тухайн бүртгэлийг шалгахдаа дараах байдлаар харна. Үүнд:**

### **1. Маягтаар**

Уг маягтын 01-р мөр 01, 02-р баганад байх 1-р ангид элсэгчдийн тоо БДБ-1 маягтын 05, 06 -р мөрний 05-р багананы дүнтэй тэнцүү байна.

Уг маягтын 01-р мөр 01, 02-р баганад байх 1-р ангид элсэгчдийн тоо БДБ-3 маягтын 02-р багананы 59,60 дугаар мөрний дүнтэй тэнцүү байна.

### **2. Бүртгэлээр**

**Статистикийн удирдлага-ийн статистикийн хяналт** хэсэгт орно.

**Нэгтгэл** цонхноос **Суралцагч** гэсэн хэсгийг дуудна.

Суралцагчийн жагсаалт хэсэгт орж excel хэлбэрээр татан авч шүүж 1-р ангийн суралцагчдын хайлтыг хийж СӨБ-д хамрагдсан эсэхийг хүүхэд тус бүрээр нь шалгах боломжтой.

**БДБ 4 маягтын үзүүлэлтийг системээс гаргах зааварчилгаа**

## **Нэгдүгээр ангид шинээр элсэгчийг тоолохдоо:**

Боловсролын удирдлагын системийн **"Суралцагч"** үйл ажиллагааны **"Шинэ суралцагч"** бүртгэж авахдаа **"Үйлдлийн шалтгаан"** дээр нь **"Шинээр элссэн"** гэж сонгосон суралцагчийг тоолно.

Хэрэв таны гаргасан **БДБ1, БДБ4** тайлангийн 1-р ангийн суралцагч зөрүүтэй байгаа тохиолдолд 1-р ангид бүртгэсэн суралцагчийн хувийн мэдээлэл хэсгээс **Хөтөлбөр, төлөвлөгөө** хэсэгт дарж **Мэдээлэл засах** үйлдэл хийж **"Үйлдлийн мэдээлэл"** хэсэгт байрлах **"Үйлдлийн шалтгаан"** -аас **"Шинээр элссэн"** гэж сонголт хийнэ.